

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг:**

“9.7.Энэ хуулийн 9.1-д заасан багцад хамаарах тусламж үйлчилгээний нарийвчилсан хүрээг тогтооход баримтлах шалгуур үзүүлэлт, журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

**2/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:**

“10.4.Гэрээг эмийн сантай байгуулах тохиолдолд энэ хуулийн 10.2-т заасан тусламж, үйлчилгээний зардлын төсвөөс бусад нөхцөлийг гэрээнд тусгана.”

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 14 дүгээр зүйлийн 14.11.2 дахь заалт:**

“14.11.2. бичгээр санал өгөхгүйгээр хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гурван удаа тасалсан;”

**2/14<sup>1</sup> дүгээр зүйл:****“14<sup>1</sup> дүгээр зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн**

14<sup>1</sup>.1. Үндэсний зөвлөл нь орон тооны бус дараах есөн гишүүнээс бүрдэх бөгөөд ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана;

14<sup>1</sup>.1.1. Засгийн газрыг төлөөлж эрүүл мэнд, нийгмийн даатгал, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг, нийт гурван хүн;

14<sup>1</sup>.1.2. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо, төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбооноос тус бүр нэг, нийт гурван хүн;

14<sup>1</sup>.1.3. даатгуулагчийг төлөөлж үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдсэн холбооноос санал болгосны дагуу эрүүл мэндээс бусад салбарын үйлдвэрчний эвлэлийн холбоо, үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас санал болгосны дагуу том болон жижиг, дунд аж ахуйн нэгжээс тус бүр нэг, нийт гурван хүн.

14<sup>1</sup>.2. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал таван жилийн хугацаагаар томилно.

14<sup>1</sup>.3. Зөвлөлийн гишүүн төлөөлөл хэрэгжүүлж байгаа байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлж хуралд оролцох бөгөөд хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд саналаа бичгээр хүргүүлнэ.

14<sup>1</sup>.4. Үндэсний зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

14<sup>1</sup>.5. Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын үр дүн, оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох ба урамшууллын дээд хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.

14<sup>1</sup>.6. Үндэсний зөвлөл ажлын албатай байна. “

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт, 9.3 дахь хэсгийн “15.1.5,” “15.1.9,” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.11, 14.12, 14.13 дахь хэсгийн “дарга, дэд дарга,” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг